

## **ХӨДӨӨ ОРОН НУТГИЙН БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ОРЧИН, НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА.**

**/Завхан аймгийн Зүүн бүсийн сумдын жишээн дээр/**

### **SURVEY OF THE ENVIRONMENT AND SITUATION OF RURAL ENTRE- PRENEURS /On the example of soums in the eastern region of Zavkhan aimag/**

Д.Бямбадорж<sup>1</sup>, Б.Болорчимэг<sup>2</sup>

#### Хураангуй

Уг судалгааны ажлаар Завхан аймгийн Зүүн бүсийн сумд болох Тосонцэнгэл, Их-Уул, Идэр, Тэлмэн сумдын нийгэм, эдийн засгийн байдал, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бизнесийн орчны өнөөгийн байдал болон ирээдүйн чиг хандлагыг тодорхойлохыг зорьсон. Судалгаанд сумдын удирдлагын баг бүрэлдэхүүн болон сонгогдсон 60 бизнес эрхлэгчдийг хамруулсан. Энэхүү судалгаанаас тус сумдын бичил бизнес эрхлэгчдийн ерөнхий мэдээлэл болоод тэдний үйлдвэр, үйлчилгээний зах зээл, санхүү, хэрэгцээ, бизнесийн орчны нөхцөл байдлын үнэлгээ, тулгарч буй бэрхшээлүүдийн талаар судлан үнэлгээ дүгнэлт өглөө.

Түлхүүр үг: Бичил бизнес эрхлэгч, бизнесийн орчин, бүтээгдэхүүний зах зээл, санхүүгийн эх үүсвэр

#### Abstract

The purpose of the research work was to determine the current social and economic situation, current and future trends of the business environment of producers and service providers in Tosontsengel, Ikh-Uul, Ider and Telmen soums of the Eastern region of Zavkhan aimag.

The survey covered soum management teams and 60 selected businesses.

The survey provided an overview of the general information of micro-entrepreneurs in these soums, as well as an assessment of their industrial and service markets, finances, needs, business environment, and challenges.

Keywords: small business, business environment, product market, financial resources

---

<sup>1</sup> МУИС-ийн Завхан сургуулийн НББТ-ийн багш  
E-mail: byambadorj.d@num.edu.mn

<sup>2</sup> МУИС-ийн Завхан сургуулийн сургалт оюутны албаны дарга  
E-mail: bolorchimeg@num.edu.mn

### **Завхан аймгийн зүүн бүсийн сумдын нийгэм эдийн засгийн өнөөгийн байдал:**

Уг судалгааг хүн ам ихтэй, ажиллах боловсон хүчний хувьд харьцангуй өндөр, мал аж ахуй болоод байгалийн баялаг сайтай, нийслэл хотоос баруун бүсд чиглэсэн засмал зам дагуу байрладаг Завхан аймгийн зүүн бүсийн сумдын хүн ам, МАА, МАА-н гаралтай бүтээгдэхүүний нөөц, ААН, тэдгээрийн үйл ажиллагааны чиглэлийн өнөөгийн байдлын талаар судалгааг хийлээ.

Сүүлийн 5 жилийн байдлаар эдгээр сумдын хүн амын өсөлт тогтвортой байна. 2016 онд Завхан аймгийн нийт хүн амын 28,93% нь амьдарч байсан<sup>3</sup> бол 2020 онд 29,13% нь амьдран суух болсон бөгөөд сумдын хүн амын дундаж өсөлт 1-1,3%-тай<sup>4</sup> байгаа нь тус бүс нутгаас бусад газар руу хүн амын шилжилт хөдөлгөөн харьцангуй багатай.

Малын төрлөөр авч үзэхэд эдгээр 4 сумдад нийт 60,6 мянган толгой адуу, 72,9 мянган толгой үхэр, 0,3 мянган толгой тэмээ, 379,5 мянган толгой хонь, 178,9 мянган толгой ямаа нутаглаж байна. Завхан аймгийн нийт адууны 25%, үхэр сүргийн 32%, тэмээн сүргийн 4%, хонин сүргийн 21%, ямаан сүргийн 13% байгаа<sup>5</sup> нь ХАА-н гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээ их байх, нэмүү өртөг шингэсэн малын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломж өндөр байгааг харуулж байна.

2020 оны байдлаар Тосонцэнгэл суманд нийт 170 ААН, Идэр суманд 35 ААН, Их-Уул суманд 54 ААН, Тэлмэн суманд 35 ААН бүртгэлтэй байна. Аймгийн нийт ААН-

<sup>3</sup>Завхан аймгийн статистикийн хэлтсийн мэдээлэл

<sup>4</sup>Завхан аймгийн статистикийн хэлтсийн танилцуулга

<sup>5</sup>www.1212.mn

<sup>6</sup>www.1212.mn

<sup>7</sup>Завхан аймгийн “Хүнс, хөдөө аж ахуй газар”-ын мэдээллээс

ийн 22% нь эдгээр сумдад үйл ажиллагаа явуулж байна<sup>6</sup>.

Зорилтот сумдад Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд албан ёсоор бүртгэлтэй нийт 273 ААН, байгууллага байгаагаас 62% нь Тосонцэнгэл суманд, 19% нь Их-Уул суманд, 11% нь Тэлмэн суманд, 8% нь Идэр суманд үйл ажиллагаа явуулж байна. Бизнесийн чиглэлээр авч үзэхэд 64% нь үйлчилгээ, 36% нь үйлдвэрлэл эрхэлж байна. Нийт үйлчилгээ эрхлэгчдийн 64%, үйлдвэрлэл эрхлэгчийн 36% нь Тосонцэнгэл суманд үйл ажиллагаа явуулж байна<sup>7</sup>.

Бусад сумдтай харьцуулахад эдгээр сумд нь ой мод, зэрлэг жимс, самар зэрэг байгалийн баялаг ихтэй. Малаж ахуй, газар тариалан, гар урлалын чиглэлүүд хөгжиж байгаа бөгөөд сүү сүүн бүтээгдэхүүн, модон эдлэл, жимс жимсгэнэ, хүнсний ногоо, оёдол, гар урлалын бүтээгдэхүүнүүд түлхүү үйлдвэрлэж байна.

Сум орон нутгийн удирдах дээд байгууллагаас орон нутгийнхаа иргэдийн үйлдвэрлэл, бизнесийг дэмжихдээ сум хөгжүүлэх сангийн зээлийг өрхийн үйлдвэр эрхлэгч нарт хүргэх зорилго тавьж ажиллаж байгаа ба жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан бусад төсөл хөтөлбөрт иргэдийг хамруулах зуучлан туслах, арга зүйн зөвлөгөө өгөх ажлуудыг урьтал болгон хэрэгжүүлж байна.

Сумдын удирдлагуудтай хийсэн хэлэлцүүлгийн үр дүнгээр сумдын жижиг дунд үйлдвэрлэл, бичил бизнесийн хүрээнд дэмжихээр төлөвлөж буй үйлдвэрлэл үйлчилгээний тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлон гаргалаа.

## Хүснэгт 1: Сумдын үйлдвэрлэл, үйлчилгээний тэргүүлэх чиглэл

	Тэлмэн	Тосонцэнгэл	Их-Уул	Идэр
I бүтээгдэхүүн	Зөөлөн оёдол	ХАА-н бүтээгдэхүүн. Үүнд:	ХАА-н бүтээгдэхүүн. Үүнд:	Сүү сүүн бүтээгдэхүүн
		А. Сүү сүүн бүтээгдэхүүн	А. Сүү сүүн бүтээгдэхүүн	
		Б. Мах, махан бүтээгдэхүүн	Б. Малын дайвар бүтээгдэхүүн	
II бүтээгдэхүүн	Сүү сүүн бүтээгдэхүүн	Талх нарийн боов	Газар тариалангийн үйлдвэрлэл	Аялал жуулчлал
III бүтээгдэхүүн	Малын тэжээл	Жимс жимсгэний үйлдвэрлэл	Жимс жимсгэний үйлдвэрлэл	Арьс ширний үйлдвэрлэл
IV бүтээгдэхүүн	Мах махан бүтээгдэхүүн	Модон эдлэл үйлдвэрлэл	Аялал жуулчлал	Мод модон бүтээгдэхүүн/ био нүүрс/
V бүтээгдэхүүн	Хоол үйлдвэрлэл	Аялал жуулчлал	Гар урлал	Жимс жимсгэний үйлдвэрлэл

*Эх сурвалж: Хэлэлцүүлгийн үр дүнгээс*

Эндээс харахад зорилтот сумд нь ХАА-н салбар, тэр дундаа МАА-н салбарын үйлдвэрлэл, байгалийн баялагт суурилсан мод, модон эдлэл үйлдвэрлэл, аялал жуулчлалын хүрээн дэх бизнес эрхлэлтийг тэргүүлэх чиглэл болгон тодорхойлж байна.

#### **Бизнес эрхлэгчдийн нөхцөл байдлын судалгаа:**

Орон нутаг дахь бизнес, үйлдвэрлэлийн онцлог, нөхцөл байдлыг тодруулах, бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлт, зах зээлийн боломжийг тодруулахын зорин дараах бүлэг хэсгээс бүрдсэн анкетын судалгааг сум тус бүрээс 15 бичил бизнес эрхлэгчдээс буюу нийт 60 хүнийг хамарсан анкетын судалгааг авсан бөгөөд үүний үр дүнг авч үзлээ.


#### **А. Ерөнхий мэдээлэл:**

Судалгаанд хамрагдсан бизнес эрхлэгчдээс 35(58%) нь эмэгтэйчүүд,

25(42%) нь эрэгтэйчүүд оролцсон. Бид хүйсийн харьцааг тэгш байхаар судалгаанд оролцогчдыг сонгохыг хичээсэн боловч хөдөө орон нутаг тэр дундаа сумдад цөөн тооны бизнес эрхлэгчид байдаг бөгөөд үүний дийлэнх хувь нь эмэгтэйчүүд байна. Судалгаанд оролцогчдыг насны бүлгээр судлан үзэхэд 41-50 насны хүмүүс дийлэнх хувийг буюу 43%-ийг, 31-40 насны иргэд 25% тай бөгөөд 31-50 насны иргэд сум орон нутгийн бизнес эрхлэгчдийн гол төлөөлөл нь болдгийг харж болно. Боловсролын түвшингөөр судлан үзэхэд бүрэн дунд болон түүнээс дээш боловсролтой хүмүүс ихэнх хувийг бүрдүүлж байгаа ч үүн дотроо бүрэн дунд болон тусгай дунд мэргэжлийн хүмүүсийн үйлдвэрлэл үйлчилгээнд оролцох хувь нэмэр их байна.

Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид нь хир олон ажилчдыг ажлын байраар хангаж чадаж байгаад судалгаа хийж үзэхэд

Зураг 1: Судалгаанд хамрагдагсдын ажиллах хүчний мэдээлэл



Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн 73% нь ажлын байр бий болгодог, судалгаанд хамрагдсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд нийт 160 ажилтан ажиллаж байгаагаас гэр бүлийн гишүүн 70, гэр бүлийн гишүүн биш 90 хүнийг ажлын байраар хангаж байна. Энэхүү судалгаанаас харахад бүтэн болон хагас цагаар ажилладаг эмэгтэй ажилчид эрэгтэй ажилчдаас илүү олон буюу нийт ажилчдын 56%-ийг бүрдүүлж тэр дундаа гэр бүлийн гишүүн биш эмэгтэй ажилчдын оролцоо өндөр байна. Харин эрэгтэй ажилчдын хувьд гэр бүлийн гишүүн биш бүтэн цагаар ажилладаг эрэгтэйчүүд нийт эрэгтэй ажилчдын 47%-ийг бүрдүүлж байна. Бичил бизнес эрхлэгчид нь 118 хүнийг байнгын ажлын байраар, 42 хүнийг түр ажлын байраар хангадаг буюу улирлын болоод баяр ёслолын үед ачаалал нэмэгдэх тохиолдолд хагас болон тогтмол биш цагаар ажиллуулж байна.

Сүүлийн 3 жилийн дунджаар бичил бизнесүүдийн 2.6%, том ААН-үүдийн 1.6% нь ажилтны тоог өсөгсөн. Харин 2020 оны байдлаар 2018 оноос ажилтны тоо

буурсан бичил бизнес эрхлэгчдийн тоо 18.5 пунктээр, жижиг бизнесийнхний тоо 18.9 пунктээр, дунд бизнесийнхний хувьд 9.7 пунктээр тус тус буурсан таагүй үр дүн гарсан байна<sup>8</sup>.

Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдээ үйл ажиллагааны чиглэлээр судлан үзэхэд:

Судалгаанд хамрагдсан бичил бизнес эрхлэгчдийн 17(28%) нь үйлчилгээний чиглэлээр, 44 (72%) нь үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг хүмүүсийг хамруулсан байна.

Үйлдвэрлэлийн хувьд: Талх нарийн боов, оёдол, цагаан идээ, модон эдлэл, газар тариалангийн үйлдвэрлэлүүд илүү түлхүү хөгжиж эхэлж байгаа учир энэхүү чиглэлүүдээр үйлдвэрлэл эрхлэгчид судалгаанд бусад үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэгчдээс илүү олон тоотойгоор хамрагдсан.


Үйлчилгээний хувьд: Худалдаа, авто засвар, цайны газар гэсэн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчид илүү олон байдаг учир энэхүү чиглэлүүдээр бусад чиглэлийн үйлчилгээ эрхлэгчдээс илүү олон тоотойгоор хамрагдсан.

<sup>8</sup> Монголын бизнесийн орчин 2020, судалгааны тайлан, хуудас 10

Б. Бүтээгдэхүүний мэдээлэл:

Зураг 2: Бүтээгдэхүүний талаарх ерөнхий мэдээлэл

/1-5 балаар үнэлэх: ач холбогдол багатай бол 1, хамгийн ач холбогдолтой бол 5/



60 үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн 190 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээнд дээрх судалгааг 1-5 баллаар үнэлүүлэн дундаж үнэлгээгээр гаргахад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид нь өөрийн үйл ажиллагааг нийгэмд ач холбогдолтой, нийгэм байгаль орчинд хор нөлөөлөл багатай ихэвчлэн хадгалалт даадаг бүтээгдэхүүн үйлчилгээг үйлдвэрлэдэг. Түүхий эд материалын олдоц боломжийн, түүхий эд материалын татан авалтын хувьд хүндрэл дундаас доогуур түвшинд байна. Улирлын хамаарлын хувьд блок, жимс жимсгэнэ, мод үржүүлэг, газар тариалан, цагаан идээ, хаалга зэрэг бүтээгдэхүүн үйлдвэрлэлүүд болон аялал жуулчлал, зочид буудал, авто засварын үйлчилгээнүүдийн хувьд улирлын хамаарал ихтэй.

Идэр болон Тосонцэнгэл сумын бичил бизнес эрхлэгчид үйлдвэрлэлээ нэмэгдүүлж нөөцөлж чаддаг. Үүнд: гар урлал, мод үржүүлэг, жимс, жимсгэнээр хийсэн бүтээгдэхүүн, блок, арьс ширэн бүтээгдэхүүн, цагаан идээ гэх мэт. Зарим нэр төрлийн хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн хувьд бүтээгдэхүүний хадгалалтад нарийн горим шаардагддаг тул хадгалалтын асуудалд хүндрэл гардаг, тоног төхөөрөмж дутагдалтай байдаг талаараа илэрхийлж байлаа.

В. Зах зээлийн мэдээлэл

Энэ хэсэгт бид үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн эрэлтийн үнэлгээг 9 үзүүлэлтээр, мөн бүтээгдэхүүн, үйлчилгээний худалдан авагчдын тоо, бүтээгдэхүүнээ борлуулж буй одоогийн зах зээл, бүтээгдэхүүн борлуулалтын Зах

зээлээ өөрчлөхөөр төлөвлөж буй эсэх, үйлдвэрлэлийн хүчин чадлын үзүүлэлт, хуваарилалтын сувгийн мэдээллүүдэд тулгуурлан зах зээлийн судалгааг хийлээ.

Хүснэгт 2: Бичил бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүний зах зээлийн эрэлтийн үнэлгээ 1-5 балаар үнэлэх /ач холбогдол багатай бол 1, хамгийн ач холбогдолтой бол 5/

33-ийн үнэлгээний үзүүлэлтүүд		Ерөнхий дундаж	Тосонцөнгэл	Их-Уул	Тэлмэн	Идэр
Эрэлтийн үнэлгээ /1-5 балаар/	Зах зээлийн эрэлтийн хэдэн хувийг хангадаг вэ? /хувиар/	37%	33%	42%	33%	36%
	Зах зээлийн эрэлт хэрэгцээ байгаа эсэх	4.23	4.30	4.19	4.14	4.28
	Улирал, баяр ёслолтой холбоотой эрэлт хэрэгцээ нэмэгддэг эсэх	4.33	4.34	4.15	4.52	4.37
	Цаашид эрэлт өсөн нэмэгдэх эсэх	4.50	4.68	4.14	4.67	4.65
	Эрэлт хэрэгцээг хангаж чадаж байгаа эсэх	3.40	3.00	3.02	3.86	3.91
	Хэрэглэгчдийн эрэлт, хэрэгцээ өөрчлөгдөж байгаа эсэх	3.70	3.77	3.15	3.83	4.23
	Өөрчлөлтийг дагаж бүтээгдэхүүнээ өөрчлөх шаардлагатай эсэх	3.86	3.94	3.66	3.62	4.30
	Бүтээгдэхүүн борлуулахтай холбоотой бэрхшээл байдаг эсэх	2.58	2.05	2.86	2.62	2.67

Дээрх эрэлтийн судалгаанаас харахад судалгаанд хамрагдаж буй сумуудын бичил бизнес эрхлэгчдийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ нь зорилтот зах зээл дээрээ эрэлттэй байна. Энэхүү эрэлтийн тодорхой хувийг үйлдвэрлэгч нар хангадаг. Бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт баяр ёслолын үеүдэд өсдөг, үйлдвэрлэл эрхлэгчид өөрийн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээг ирээдүйд өсөн нэмэгдэнэ гэсэн өөдрөг төсөөлөлтэйгөөс гадна хэрэглэгчийн зан төлөвтэй холбоотойгоор бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлтэд бага зэргийн өөрчлөлт ордог бөгөөд энэхүү өөрчлөлтийг дагаж бүтээгдэхүүн, үйлчилгээндээ өөрчлөлт хийх чадвартай гэж үзлээ.

## Хүснэгт 3: Бүтээгдэхүүнээ борлуулж буй одоогийн зах зээлийн судалгаа /

Бүтээгдэхүүнээ борлуулж буй одоогийн зах зээл	Сумдаа	Бусад сумдад	Аймаг, бусад	УБ-т	Гадаад
Тосонцэнгэл	46	22	13	14	2
Их-Уул	55	26	20	17	3
Тэлмэн	42	11	0	5	0
Идэр	43	19	14	11	0
Нийт дүн /Бүтээгдэхүүний нэр төрлөөр, давтагдсан тоогоор/	186	78	47	47	5

Дээрх судалгаанаас үзэхэд бичил бизнес эрхлэгчид нь дийлэнх бүтээгдэхүүн үйлчилгээгээ өөрийн сумдад борлуулалтуудыг хийдэг бол бусад сум, аймаг, Улаанбаатар хор руу дунджаар 57 нэр төрлийн бүтээгдэхүүнүүдийг борлуулж байна. Тэр дундаа Тосонцэнгэл болон Их-Уул сумдын үйлдвэрлэл эрхлэгчдийн хувьд борлуулалтын зах зээлээ олон талаар нэмэгдүүлэх тал дээр анхаарч байгаа нь харагдаж байна. Аймаг, Улаанбаатарын зах зээл дээр борлуулалт хийж буй бүтээгдэхүүнийг нэр төрлөөр нь задлан үзвэл модон эдлэл, гутал үйлдвэрлэл, гөлөм, гар урлал, цагаан идээ, еэвэн, хэвийн боов, варень, өтгөрүүлсэн жүүс зэргийг борлуулж байна. Гадаадад борлуулалт хийж буй бүтээгдэхүүнийг үзэхэд Монгол гутал, еэвэн, хэвийн боов зэргийг цөөн тоогоор борлуулж байна.

Бичил бизнес эрхлэгчдээс 99 нэр төрлийн бүтээгдэхүүний борлуулалтын хувьд зах зээлийн хүрээгээ тэлэн бусад сум, аймаг, Улаанбаатарт бүтээгдэхүүний борлуулалт хийхээр төлөвлөж байгаа бөгөөд дийлэнх хувь нь бусад сумдад борлуулалт хийхийг зорьж байгаа бол Аймаг, Улаанбаатарын зах зээлд еэвэн, хэвийн боов, дээл хувцас, варень, жүүс, модон эдлэл, хүнсний ногоо, цагаан идээ, арьс ширэн бүтээгдэхүүн

борлуулалт хийхээр төлөвлөж байна.

Бизнес эрхлэгчид гадаад худалдаа эрхлэх нөхцөл байдлыг хүндрэлтэй гэж үнэлсэн ба дийлэнх нь экспорт, импортын зөвшөөрөл авахад зарцуулах хугацаа их, зөвшөөрөл авахын тулд бүрдүүлэх бичиг баримтын тоо олон, зөвшөөрөл авахад гарах зардал, төлбөр хураамжийн хэмжээ өндөр гэж хариулсан. Валютын ханшийн хэлбэлзлийн нөлөө маш их хүндрэл үүсгэж байгааг онцгойлон анхаарах шаардлагатай байна. Мөн экспорт, импорт хийхэд дотоодын тээврийн зардал өндөр, тээвэрлэлтэд зарцуулах хугацаа их, тээврийн олдоц, хүрэлцээ хангалтгүй байгаа нь гадаад худалдаа эрхлэхэд сөрөг нөлөө үзүүлж байна<sup>9</sup>.

<sup>9</sup> Монголын бизнесийн орчин 2020, судалгааны тайлан, хуудас 9



Хүснэгт 4: “Бүтээгдэхүүнээ борлуулж буй хуваарилалтын суваг” /сумаар/

Бүтээгдэхүүнээ борлуулж буй хуваарилалтын суваг	Үйлдвэрлэгч-хэрэглэгч	Үйлдвэрлэгч-жижиглэнгийн худалдаа-хэрэглэгч	Үйлдвэрлэгч-бөөний худалдаа-жижиглэнгийн худалдаа-хэрэглэгч	Үйлдвэрлэгч-зуучид-бөөний худалдаа-жижиглэнгийн худалдаа- хэрэглэгч
Тосонцэнгэл	41	16	6	3
Их-Уул	43	18	7	7
Тэлмэн	42	11	4	0
Идэр	35	4	6	5
Нийт дүн	161	49	23	15

Дээрх судалгаанаас үзэхэд бичил бизнес эрхлэгчид нь бүтээгдэхүүнийхээ дийлэнх хувийг үйлдвэрлэгчээс хэрэглэгчид шууд хүргэх буюу “0” түвшний хуваарилалтын сувгийг ашигладаг бөгөөд цөөн хэдэн бүтээгдэхүүн үйлчилгээний хувьд бусад хуваарилалтын сувгаар бүтээгдэхүүн, үйлчилгээгээ хэрэглэгчдэд хүргэдэг байна. Үүнээс үзэхэд бичил бизнес эрхлэгчид нь бүтээгдэхүүнээ түгээх хуваарилалтын

сувгийг нэмэгдүүлэх тал дээр хангалттай ажиллаж чадахгүй энэ талын мэдлэг дутмаг байдаг нь ажиглагдлаа.

Г. Санхүүгийн мэдээлэл:

Энэ хэсэгт бид үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бизнесээс олох борлуулалтын ашиг, үндсэн үйл ажиллагааны ашиг болоод бизнесээс олсон ашгийн зарцуулалтад судалгааг хийж үзлээ.

Хүснэгт 5: Ашигт ажиллагааны ерөнхий үзүүлэлт: /пунктээр/


Үйлдвэрлэл	Борлуулалтын ашигт ажиллагаа	Үндсэн үйл ажиллагааны ашигт ажиллагаа	Үйлчилгээ	Борлуулалтын ашигт ажиллагаа	Үндсэн үйл ажиллагааны ашигт ажиллагаа
Оёдол	0.42	0.79	Цайны газар	0.46	0.97
Гутал	0.06	1.12	Буудал	0.40	0.67
Гар урлал	0.52	2.62	Аялал жуулчлал	0.00	0.00
Модон эдлэл	0.54	1.69	Авто засвар	0.38	0.75
ХАА	0.44	1.29	Засвар үйлчилгээ	0.50	1.00
Хүнс	0.34	0.67	Үсчин гоо сайхан	0.39	0.63
Блок	0.34	0.62	Худалдаа	0.14	0.18
Хашаа хаалга	0.51	1.03			



Дээрх судалгаанаас үзэхэд нэгж бүтээгдэхүүнээс хүртэх борлуулалтын ашгийн хувьд гар урлал, модон эдлэл, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүд буюу хүнсний ногоо, арьсширэн бүтээгдэхүүнүүд борлуулалтын ашигт ажиллагаа сайтай болох нь харагдаж байна. Үйлдвэрлэл эрхлэгчдийн хувьд олж буй борлуулалтын ашиг нь бүтээгдэхүүний өөрийн өртгөөс илүү байдаг буюу үйлчилгээний салбараас илүү ашиг хүртэж байгаа нь харагдаж байна.


Бичил бизнес эрхлэгчид нь үйл ажиллагааны үр дүнд санхүүгийн хувьд ашиг хүртэж чадаж байгаа буюу нийт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн 95% нь тодорхой хэмжээний ашигтай ажиллаж чадсан байна.

Зураг 3: Бизнесийн ашгийн зарцуулалт:



Ашгийн зарцуулалтыг судлан үзэхэд дунджаар олсон ашгийн 45%-ийг бизнестээ хөрөнгө оруулахад зарцуулж байгаа бол 64%-ийг өрхийн хэрэгцээндээ буюу 36%-ийг нь хоол хүнс, гэр ахуйн зардалд, 28%-ийг нь боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр зарцуулдаг бөгөөд үлдсэн хувийг хуримтлал болоод бусад зүйлд зарцуулж байна.

Бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэрийн талаарх мэдээлэл.



- Зөвхөн өөрийн хөрөнгөөр
- Дийлэнх хувийг зээлийн санхүүжилтээр
- Өөрийн болон зээл төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр

Бизнесийн үйл ажиллагааны санхүүжилтийн эх үүсвэрт судалгаа хийж үзэхэд 45% нь зөвхөн өөрийн хөрөнгөөрөө, 47% нь бизнестээ ашиглаж буй хөрөнгийн дийлэнх хувийг зээлийн санхүүжилтээр санхүүжүүлсэн бол 8% нь хөнгөлөлттэй зээл болон төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр хөрөнгөө санхүүжүүлсэн. Нийт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн 43% нь хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрийн санхүүжилтэд хамрагдах хүсэлтэйгээ илэрхийлсэн. Аж ахуй нэгжийн хувьд зээл авах нь шаардлага өндөр байдаг тул шаардлагатай санхүүжилтээ эзэн эсвэл гэр бүлийн гишүүний нэр дээр зээл авч санхүүжилт авдаг байна. Судалгаанд хамрагдсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдээс 8 саяас дээш хөрөнгө оруулалт шаардлагатай 17 (28%), 5-8 сая хүртэлх хөрөнгө оруулалт шаардлагатай 12(20%), 2-5 сая хүртэлх хөрөнгө оруулалт шаардлагатай 17(28%), 2 сая хүртэлх хөрөнгө оруулалт шаардлагатай 13(22%) аж ахуй нэгж байна. Үүнийг үйл ажиллагааны төрлөөр нь задлан үзвэл оёдол, гутал үйлдвэрлэл, гар урлалын үйлдвэрүүд болон үсчин, гоо сайхан, засвар үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдэд 5 сая хүртэлх

төгрөгийн санхүүжилт шаардлагатай. Харин модон эдлэл, хөдөө аж ахуй, хүнс үйлдвэрлэгчид болон цайны газар, зочид буудал, аялал жуулчлал, худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдийн дийлэнх хувьд нь 5 саяас дээш төгрөгийн санхүүжилт шаардагдаж байна<sup>10</sup>.

Д. Бизнесийн орчин, хэрэгцээ:

Бид судалгааны энэ хэсэгт бичил бизнес эрхлэгчдийн ур чадварын үнэлгээ, нэн тэргүүнд сайжруулах шаардлага бүхий ур чадварууд, бизнесийн сургалт хөтөлбөрт хамрагдах хүсэл эрмэлзэл, бизнесийн орчны үнэлгээ болоод бичил бизнес эрхлэгчдийн хязгаарлагдмал боломжуудын талаар судлан харууллаа.

Хүснэгт 6: Бичил бизнес эрхлэгчдийн нэн тэргүүн дээшлүүлэх шаардлагатай ур чадварууд:

	Тосонцөнгэл	Их-Уул	Тэлмэн	Идэр
I дээшлүүлэх чадвар	Гадаад хамтын ажиллагаагаа өргөтгөх, гэрээ хэлэлцээр хийх чадвар	Гадаад хамтын ажиллагаагаа өргөтгөх, гэрээ хэлэлцээр хийх чадвар	Гадаад хамтын ажиллагаагаа өргөтгөх, гэрээ хэлэлцээр хийх чадвар	Гадаад хамтын ажиллагаагаа өргөтгөх, гэрээ хэлэлцээр хийх чадвар
II дээшлүүлэх чадвар	Санхүүгээ удирдах болон нягтлан бодох бүртгэл хөтлөх, тооцоо судалгаа гаргах	Бизнесийн эрх зүйн талаарх мэдлэг чадвар	Бизнес төлөвлөгөө боловсруулах, хөгжүүлэх	Бизнес төлөвлөгөө боловсруулах, хөгжүүлэх
III дээшлүүлэх чадвар	Бизнесийн эрх зүйн талаарх мэдлэг чадвар	Бизнес төлөвлөгөө боловсруулах, хөгжүүлэх	Санхүүгээ удирдах болон нягтлан бодох бүртгэл хөтлөх, тооцоо судалгаа гаргах	Санхүүгээ удирдах болон нягтлан бодох бүртгэл хөтлөх, тооцоо судалгаа гаргах

Бизнес эрхлэгчдийн ур чадварын үнэлгээнээс сумуудаар нь хамгийн бага баллын үнэлгээтэйгээр задлан, ахиулах шаардлагатай ур чадваруудыг эрэмбэлэн үзэхэд хамгийн бага үнэлгээтэй буюу нэн тэргүүнд анхаар ч ахиулах ур чадвар нь гадаад хамтын ажиллагаагаа нэмэгдүүлэх, гэрээ хэлэлцээр хийх чадвар, хоёр болон гуравт бизнес төлөвлөгөө боловсруулах,

санхүүгээ удирдах, хөтлөх, бизнесийн эрх зүйн талаарх мэдлэг ур чадваруудыг дээшлүүлэх шаардлагатай нь харагдаж байна.

Бичил бизнес эрхлэгчдийн дийлэнх нь буюу 49(82%) нь өөрийн бизнесээ хөгжүүлэх тал дээр өөрийгөө бэлтгэх, хөгжүүлэх, үйл ажиллагаандаа дэмжлэг бизнесийн чиглэлээрх сургалт, бизнесийн


<sup>10</sup> Бичил бизнес эрхлэгчдэд хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг хэрэгтэй гэдэг нь харагдаж байна.

үйл ажиллагааг дэмжих хөтөлбөрүүдэд хамрагдах хүсэлтэй байдаг байна.

Бизнесийн орчны ерөнхий үнэлгээг улсын

хэмжээгээр гаргасан Монголын бизнесийн орчин 2020, судалгааны тайлангийн мэдээллээс үзэхэд.

Зураг 5: Бизнесийн орчны ерөнхий үнэлгээ /Улсын хэмжээнд ААН-ийн




2020 оны байдлаар Монголын бизнесийн орчны ерөнхий үнэлгээ 2.91 буюу дундаж түвшинд үнэлэгдсэн байна. Үнэлгээний үзүүлэлтүүдээр нь авч үзвэл Засаглал, хууль эрх зүйн орчин 2.66, Эдийн засгийн орчин 2.67, хамгийн бага үнэлгээг авсан бол. Нийгэм соёлын орчин 2.87 дундаас доогуур муу талдаа үнэлэгдсэн. Харин

дэд бүтэц, технологийн орчин 3.23, байгууллагын дотоод орчин 3.13 дундаас дээгүүр үнэлэгдсэн байна<sup>11</sup>.

Орон нутгийн бизнесийн орчин, бизнес эхлэх, өргөжүүлэхэд таатай эсвэл таагүй нөлөөлж буй байдлыг тодорхойлохын тулд дараах чиглэлүүдээр баллын үнэлгээгээр судлан үзлээ.

Зураг 6: Бизнесийн орчны үнэлгээ:

/Маш хязгаарлагдмал – 1, Ерөнхийдөө хязгаарлагдмал – 2, Ерөнхийдөө боломжтой – 3, Маш боломжтой – 4, Мэдэхгүй – 5./



Бичил бизнес эрхлэгчдийн хувьд холбогдох хууль тогтоомж, зохицуулалт, зонхилох соёл ба засаглал, түүхий эд материал, үнэ ханш, зах зээл зэрэг шаардлагатай мэдээлэл олж авах боломж, мэдээлэл, холбоо технологийн дэд бүтэц ашиглах боломж, нийтийн үйлчилгээний дэд бүтцийн хүртээмж (цахилгаан, ус, хог

хаягдал г.м), бэлтгэн нийлүүлэгчидтэй холбогдох, орц материалаа хангах боломж, хүсч буй зах зээл, хэрэглэгчиддээ хүрэх боломжтой гэж үзсэн бол дараах чиглэлээр анхаарах буюу бизнесийн орчинд хязгаарлагдмал нөлөөллийг үзүүлдэг гэж хариулсан байна.

Хүснэгт 7: Бичил бизнес эрхлэгчдийн хязгаарлагдмал боломжууд:

№	Тосонцэнгэл		Их-Уул		Тэлмэн		Идэр	
1	Санхүүгийн дэмжлэг авах боломж	1.9	Санхүүгийн дэмжлэг авах боломж	2.5	Санхүүгийн дэмжлэг авах боломж	2	Санхүүгийн дэмжлэг авах боломж	2.3
2	Бизнесийн үйлчилгээнд хамрагдах боломж	2.4	Бизнесийн үйлчилгээнд хамрагдах боломж	2.5	Бизнесийн үйлчилгээнд хамрагдах боломж	2.4	Үйлдвэрлэлийн тусгай технологи эзэмших боломж	2.5
3	Үйлдвэрлэлийн тусгай технологи эзэмших боломж, Нийтийн үйлчилгээний дэд бүтцийн хүртээмж (цахилгаан, ус, хог	2.9	Бэлтгэн нийлүүлэгчидтэй холбогдох, орц материалаа хангах боломж, дэд бүтцийг ашиглах боломж	2.7	Үйлдвэрлэлийн тусгай технологи эзэмших боломж	2.8	Шаардлагатай дэд бүтцийг ашиглах боломж	2.7

Бичил бизнес эрхлэгчдийн хувьд санхүүгийн дэмжлэг авах боломж, бизнесийн үйлчилгээнд хамрагдах боломж, үйлдвэрлэлийн тусгай технологи эзэмших боломжууд ерөнхийдөө хязгаарлагдмал байдаг. Мөн Идэр сумын хувьд шаардлагатай дэд бүтцийг ашиглах боломж, Их-Уул сумын хувьд бэлтгэн нийлүүлэгчидтэй холбогдох, орц материалаа хангах боломжууд хязгаарлагдмал гэж үзсэн байна<sup>12</sup>.

Бизнес эрхлэгчид Засгийн газар

(44.8%), Орон нутгийн засаг захиргааны байгууллагын (24.3%) дэмжлэг тэдний бизнест хамгийн чухал хэрэгцээтэй гэж үзсэн.

Монгол улс экспортыг дэмжих бодлогын хүрээнд эхний ээлжид бизнес эрхлэгчдийг санхүүжилтийн эх үүсвэр олоход (72.9%) нь төрийн зүгээс бодлогоор тууштай дэмжих, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, маркетингийн зөвлөгөө (63.9%) болон гадаад зах зээлд гарахад чиглэсэн сургалт, зөвлөх үйлчилгээ (59.8%)-ний чанар, хүртээмжийг

нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарах хэрэгтэй байна<sup>13</sup> гэж үзжээ.

Е. Бизнес тулгамдаж буй сорилт, бэрхшээл

Хүснэгт 8: Бичил бизнес эрхлэгчдэд тулгамдаж буй сорилт, бэрхшээл:

А. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй холбоотой сорилт:	Б. Борлуулалт, маркетингтай холбоотой сорилт:
<ul style="list-style-type: none"> <li>• Санхүү, хөрөнгийн дутагдалтай байдал</li> <li>• Ажлын байрны асуудлууд</li> <li>• Ажиллах хүчний нөөц дутмаг</li> <li>• Тоног төхөөрөмжийн дутагдалтай байдал</li> <li>• Бүтээгдэхүүний хадгалалтын асуудал</li> <li>• Цар тахлын улмаас хөл хорио тогтоосноор үйлдвэрлэл тасрах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Сумын хүн амын худалдан авах чадвар муу тул бүтээгдэхүүнээ хямд борлуулах шаардлагатай болдог, (Орон нутгийн гэсэн шалтгаанаар хямд авах сонирхолтой)</li> <li>• Бүтээгдэхүүнээ удаан хадгалах боломж дутмаг учир хурдан борлуулахын тулд хямд борлуулдаг</li> <li>• КОВИД цар тахлын нөлөөгөөр борлуулалт зогсох</li> <li>• Борлуулалтын цэг, борлуулалтаа нэмэгдүүлэх чадвар дутмаг</li> <li>• Сав, баглаа боодлын асуудлууд</li> <li>• Аймаг, бусад сумд, Улаанбаатарт борлуулалт хийхэд тээврийн зардал өндөр гардаг.</li> </ul>

Бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт, маркетингтай холбоотойгоор тулгарч буй сорилт, бэрхшээлийн талаар судлан үзэхэд ихэнх үйлдвэрлэгчид хөрөнгө, санхүү, ажлын байр, тоног төхөөрөмжийн дутагдалтай байдал, тогтвортой ажиллах хүчний асуудал нь өргөжин хөгжихөд том бэрхшээл болдог мөн борлуулалттай холбоотойгоор бүтээгдэхүүнээ хямд үнээр борлуулах, үнийн өсөлт, тээврийн зардал өндөр гарах, цар тахал, орон нутгийн

иргэдийн худалдан авах чадвар муу байдаг нь том бэрхшээл болдог. Монгол Улсад шинээр бизнес эрхлэхэд хүндрэлтэй (2.44) байна. Ялангуяа бизнесээ эхлүүлэхэд хөрөнгө, санхүүжилт дутагдалтай (2.17), шинэ бизнес эхлүүлэх зардлыг гаргахад хүндрэлтэй (2.35), бизнес эрхлэхийн тулд авдаг техникийн нөхцөл, зөвшөөрлийн процесс төвөгтэй, хүнд сурталтай (2.34) гэжээ<sup>14</sup>.

<sup>12</sup> Монголын бизнесийн орчин 2020, судалгааны тайлан, хуудас 9

<sup>13</sup> Монголын бизнесийн орчин 2020, судалгааны тайлан, хуудас 9

<sup>14</sup> Монголын бизнесийн орчин 2020, судалгааны тайлан, хуудас 8

### **ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:**

Хөдөө орон нутгийн бичил бизнес эрхлэгчдийн дийлэнх нь 40-с дээш насны бүрэн дунд болон тусгай боловсролтой эмэгтэйчүүд бүрдүүлж байна. Энэхүү 60 бичил бизнес эрхлэгчдийн 73% нь ажлын байрыг бий болгож 150 орчин хүнийг өдрийн бүтэн болон хагас цагаар ажиллуулж өрх гэр болоод орон нутгийн эдийн засагт хувь нэмрээ оруулж байна.

Дотоодын аялагчдын урсгал эдгээр сумдаар дайран өнгөрч байгаа учир үүнийгээ дагаад гар урлал, нутгийн нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл болон зочид буудал гэр бааз бүхий амралтын газрын үйлчилгээний чиглэлүүд хөгжих боломж байгаа нь харагдаж байлаа.

Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн 67% нь бизнесийн чиглэлийн сургалт болоод бизнесийг дэмжих хөтөлбөрт хамрагдаж байгаагүй учир гадаад хамтын ажиллагаагаа нэмэгдүүлэх, гэрээ хэлэлцээр хийх, бизнес төлөвлөгөө боловсруулах, санхүүгээ удирдах, хөтлөх, бизнесийн эрх зүйн талаарх мэдлэг ур чадварууд маш дутмаг бөгөөд эдгээр ур чадварыг дээшлүүлэхэд шаардлагатай сургалт нөлөөллийн ажлууд дутагдаж байгаа нь харагдаж байна.

Бизнесээ санхүүжүүлэх эх үүсвэр олоход төвөгтэй, эрх бүхий байгууллагаас техникийн нөхцөл, зөвшөөрөл авахад хүндрэлтэй, хууль шүүхийн байгууллагын үйл ажиллагаа хангалтгүй байгаа нь бизнес эрхлэхэд саад учруулж байна гэж үзсэн. Харин татварын орчин, шинэ бизнесээ болон өмч хөрөнгөө бүртгүүлэх үйл явц, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах байдал дундаж түвшинд гэсэн байна.

Бичил бизнес эрхлэгчдийн хувьд өөрийн дотоод нөөц болох үйлдвэрлэлийн байгууламж, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ажиллах хүчний нөөц боломж дунд түвшинд байгаа тул үйлдвэрлэл үйлчилгээгээ өргөтгөх, борлуулалтаа нэмэгдүүлэхэд хүндрэл бэрхшээл болдог тул дээрх нөөцөд чиглэгдсэн оновчтой бодлого үр дүнтэй арга хэмжээ, дэмжлэг авч хэрэгжүүлбэл бичил бизнесийн төвшнөөс жижиг дунд үйлдвэрлэгчийн түвшинд хүрэх боломжтой. Эдгээр бичил бизнес эрхлэгчдийн хувьд бизнесийн ерөнхий ур чадвар дундаж учир бизнесийн сургалт, төсөл хөтөлбөрүүдэд хамрагдан ур чадвараа нэмэгдүүлэх хүсэлтэйгээс гадна бизнесийн өөрийн дотоодын нөөц боломж дунд түвшинд байдаг бөгөөд санхүүгийн дэмжлэг авах боломж, үйлдвэрлэлийн тусгай технологи эзэмших боломжууд маш хязгаарлагдмал байдаг байна.

Бичил бизнес эрхлэгчид өөрсдийн борлуулалтын дийлэнх хувийг өөрийн суманд хийдэг бөгөөд борлуулалттай холбоотой хүндрэл, бэрхшээл харьцангуй бага гардаг гэж байгаа хэдий ч борлуулалтын суваг нь хумигдмал, борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх талын мэдлэг дутмаг нь ажиглагдаж байсан. Мөн зарим бичил бизнес эрхлэгчдийн хувьд үйлдвэрлэлээ өргөтгөн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийг нэмэгдүүлэхэд тогтвортой ажиллах хүний нөөц байдаггүй гэж үзэж байлаа.

Бичил бизнес эрхлэгчид нь үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэрээ өөрийн болоод зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлэн үйл ажиллагаагаа явуулж ихэнх нь тодорхой хэмжээний ашигтай ажиллан олсон ашгийн тодорхой хэсгийг бизнестээ зарцуулж байгаа



хэдий ч тэдэнд санхүүжилтийн дутагдалтай байдал их байдаг тул санхүүгийн дэмжлэг хэрэгтэй байна. Дүгнэлтэд тулгуурласан зөвлөмжийг дараах гаргалаа

Дүгнэлт	Зөвлөмж
Хөрөнгө, санхүүгийн нөөц боломж дутмаг, санхүүжилт авах боломж хязгаарлагдмал .	<ul style="list-style-type: none"> <li>• Банкны зээлийн санхүүжилтийн эх үүсвэрээс гадна бусад хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрийн санхүүжилтүүдийг ашиглах мэдлэг дутмаг учир энэ чиглэлийн мэдээллээр байнга хангах</li> <li>• Хоорондоо хамтран ажиллах, бүлэг нэгдэл, нөхөрлөл, хоршоо үүсгэх</li> </ul>
Бүтээгдэхүүний борлуулалтын дийлэнх хувийг сумандаа хийдэг, борлуулалтын суваг болоод бүтээгдэхүүний зах зээлийн талаарх мэдлэг дутмаг	<ul style="list-style-type: none"> <li>• Бүтээгдэхүүний зах зээлийн хүрээгээ тэлэх</li> <li>• Бүтээгдэхүүнээ борлуулах борлуулалтын сувгаа нэмэгдүүлэх</li> <li>• Бүтээгдэхүүнээ цахим хэлбэрээр сурталчлан олон нийтэд таниулах</li> <li>• Аймгийн төвд сумуудын онцлог брэнд бүтээгдэхүүнийг борлуулдаг борлуулалтын нэгдсэн цэгтэй болох</li> <li>• Сум орон нутагтаа өөрийн сумын нэрийн бүтээгдэхүүний борлуулалтын цэгтэй болох</li> </ul>
Зарим үйлдвэр, үйлчилгээний чиглэлээрх тогтвортой ажиллах хүчний нөөц, мэргэжлийн боловсон хүчин дутмаг.	<ul style="list-style-type: none"> <li>• Орон нутагтаа хэрэгцээ шаардлагатай байгаа үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр тусгайлан хүн бэлтгэн бодлогоор дэмжин ажиллах</li> </ul>
Хумигдмал зах зээлтэй орчинд ижил төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид хоорондоо өрсөлддөг. Бүтээгдэхүүн үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл цөөн түгээмэл	<ul style="list-style-type: none"> <li>• STARTUP, шинэ бизнес санааг хөгжүүлэх</li> <li>• Өөрийн орон нутгийн нөөц боломжид тулгуурласан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бодлогоор дэмжих</li> </ul>
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн нэр төрлийг нэмэгдүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>• Сумын нөөцөд суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.</li> <li>• Цагаан идээ болон малын хаягдал бүтээгдэхүүнийг ашиглах үйлдвэрлэлийг хөгжүүлэх. Тухайлбал: <ul style="list-style-type: none"> <li>- Шар сүүгээр цэлцэгнүүр, ундаа хийх</li> <li>- Малыг аргал, бууц, модны үртэс, зомгол, ясыг ашиглах био нүүрсний үйлдвэрлэлийг бодлогоор дэмжих</li> </ul> </li> </ul>
Сүүлийн жилүүдэд МАА-н гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэл, сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж байгаа нь сайн юм. Гэхдээ зарим нөөцөд суурилсан үйлдвэрлэл огт байхгүй байна.	<p>МАА-н гаралтай түүхий эдийн нөөцөд тулгуурласан үйлдвэрүүдийг бий болгоход бодлогоор дэмжих, төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран ажиллах нь зүйтэй байна. Тухайлбал,</p> <ul style="list-style-type: none"> <li>- Малыг махаар борц бэлтгэн чанар стандартын дагуу савлан борлуулах</li> <li>- Сүүгээр зайрмаг хийх</li> <li>- Сарлагийн хөөврийн нөөцөд тулгуурлан бизнесийг хөгжүүлэх</li> </ul> <p>боломжтой байгаа бөгөөд үйлдвэрлэлийн хүрээнд дэх бодлого хөтөлбөрөө тодорхойлохдоо шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаа шинжилгээнд суурилах нь чухал юм.</p>



Ашигласан материал:

- Монголын бизнесийн орчин 2020, судалгааны тайлан,
- Завхан аймгийн “Хүнс, хөдөө аж ахуй газар”-ын мэдээллээс
- Завхан аймгийн статистикийн хэлтсийн мэдээлэл
- Завхан аймгийн статистикийн хэлтсийн танилцуулга
- [www.1212.mn](http://www.1212.mn)